



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 12 сарын 11 өдөр

Дугаар A/577

Улаанбаатар хот

Г Журам шинэчлэн батлах тухай Т

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

- “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ыг нэгдүгээр, “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлэх мэдээ, мэдээллийн төрөл, давтамж, мэдээлэх хугацаа”-г хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- Уг тушаалтыг мөрдлөг болгож ажиллахыг тус яамны газар, хэлтсийн дарга, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал наарт үүрэг болгосугай.
- Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Э.Содномжамц)-д даалгасугай.
- Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2012 оны 379 дүгээр тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081990

Эрүүл мэндийн сайдын
2018 оны 11 сарын 11... өдрийн
15/ дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг
мэдээллээр хангах журам

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 05 дугаар зарлигаар батлагдсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ыг хэрэгжүүлэх, мэдээ, мэдээллийн шуурхай байдал, зохицуулалтыг сайжруулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2 Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг (цаашид Зөвлөл гэх) мэдээллээр хангахтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.3 Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 12.1-д заасны дагуу байгууллага, албан тушаалтан өөрийн чиг үүрэг, бүрэн эрхийнхээ хүрээнд Зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэхээр авсан арга хэмжээ, түүний үр дүнг тогтоосон хугацаанд мэдээлэх үүрэгтэй.

1.4 Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигаар батлагдсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын нэгдүгээр хавсралт дах мэдээ, мэдээллийг заагдсан хугацаанд Зөвлөлд хүргүүлэх ажлыг Зөвлөлийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах үйл ажиллагаа хариуцсан ажилтан зохион байгуулна.

1.5 Журмын хавсралтад заагдаагүй шаардлагатай нэмэлт мэдээ, мэдээллийг тухайн асуудлыг хариуцсан албан тушаалтан гаргаж Зөвлөлд хүргүүлнэ.

1.6 Зөвлөлд хүргүүлэх мэдээллийг Төрийн нарийн бичгийн даргын гарын үсэг бүхий албан тоотоор “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд” гэж хаяглан хүргүүлнэ. Цаасаар хүргүүлж байгаа мэдээллийг цахим хэлбэрээр (flash, CD гэх мэт) хавсаргах бөгөөд мэдээллийн нууцлалыг хангах арга хэмжээг авсан байна. Нууцын зэрэглэлтэй мэдээллийг зөвхөн Зөвлөлийн нарийн бичгийн даргад холбогдох журмын дагуу хүргүүлнэ.

1.7 Зөвлөлд хүргүүлэх мэдээллийг Төрийн тусгай шуудангаар эсвэл тусгай томилсон ажилтнаар биечлэн хүргүүлнэ.

Хоёр. Зөвлөлд хүргүүлэх мэдээллийн ангилал

2.1 “Яаралтай мэдээ” гэж хугацаа хожимдвол үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд хохирол учруулахуйц үйл явдлын тухай мэдээ, Зөвлөлөөс албан хэрэгцээнд нэн даруй ирүүлэхийг шаардсан мэдээ,

2.2 “Шуурхай мэдээ” гэж тухайн үед болсон үйл явдал, хэргийн талаарх мэдээлэл,

2.3 “Танилцуулах мэдээ” гэж үйл явдлын товч танилцуулга, тодорхой дүгнэлт, санал бүхий мэдээлэл,

2.4 “Танилцуулах тойм мэдээ” гэж тодорхой хугацааны үйл явдлыг тоймлож, түүний явц, өрнөлд үнэлэлт, дүгнэлт өгсөн, цаашид авах арга хэмжээний саналыг тусгасан мэдээ,

2.5 “Тайлан мэдээ” гэж үндэсний аюулгүй байдлыг хөнгөн үйл ажиллагааг тухайн салбар, байгууллагын хүрээнд хэрхэн зохион байгуулж, хэрэгжүүлсэн, гарсан үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын тухай тайлагнасан мэдээг хэлнэ.

Гурав. Зөвлөлийг мэдээллээр хангах

3.1 Тус яамны газар, хэлтсийн дарга, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нар энэхүү журмын хавсралт 2-ын дагуу мэдээлэх, мэдээллээр хангах үүрэгтэй.

3.2 Журмын хавсралт 2-ын дагуу жилийн болон улирлын тайлан мэдээг холбогдох газар хэлтэс, шуурхай мэдээг олон нийттэй харилцах, тандалт, шуурхай удирдлагын хэлтэс нэгтгэн хугацаанд Зөвлөлд хүргүүлэх ажлыг тус тус зохион байгуулна.

3.3 Мэдээ, мэдээлэл нь Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан үндсэн зарчимд тулгуурласан, бодит мэдээлэлд үндэслэсэн, товч, тодорхой, цэгцтэй байх бөгөөд мэдээллийн агуулга, үнэн зөв байдал, чанарыг мэдээлэл бэлтгэсэн мэргэжилтэн, газар, хэлтэс, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал хариуцна.

3.4 Төрийн болон албаны нууцын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-д зааснаар мэдээний нууцын зэрэглэлийг илгээгч байгууллага шийдвэрлэнэ.

Дөрөв. Нийгмийн эрүүл мэндэд ноцтой байдал байж болзошгүй тохиолдлын талаарх мэдээлэл

4.1 Нийгмийн эрүүл мэндэд ноцтой байж болзошгүй тохиолдол гэдэг нь хүн амын эрүүл мэндэд уг тохиолдлын үзүүлэх нөлөө ноцтой, ер бусыг буюу гэнэтийн шинжтэй, улс оронд болон олон улсад тархах аюул ихтэй, бус нутагт хөл хорио тогтоо шаардлага үүссэн нөхцөл байдлыг хэлнэ. Нийгмийн эрүүл мэндэд ноцтой байдал байж болзошгүй тохиолдлын талаарх мэдээг Зөвлөлд тухай бүр шуурхай хүргүүлнэ.

4.2 Халдварт өвчний дэгдэлтийг эрт сэргэжилүүлэх, хариу арга хэмжээ авах тогтолцоонд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Олон улсын эрүүл мэндийн дүрмийн дагуу нийгмийн эрүүл мэндэд ноцтой байж болзошгүй тохиолдлын А зэрэглэлд багтсан дараах өвчлөл, хам шинжийг мэдээлнэ.

4.2.1 Шинэ болон сэргэж буй халдварууд (1 тохиолдол бүртгэгдсэн үед):

- ✓ Цагаанцэцэг
- ✓ Зэрлэг полиовирусээр үүсгэгдсэн полиомиелит
- ✓ Шинэ дэд төрлөөр үүссэн хүний томуу
- ✓ Амьсгалын цочмог халтай хамшинж
- ✓ Шинэ халдварууд

- ✓ Холер
- ✓ Дэгдэлт хэлбэрээр гарсан халдварт өвчин
- ✓ Гэдэсний балнад
- ✓ Хоолны хордлогот халдварт
- ✓ Менингококкийн халдварт

4.2.2 Зоонозын халдварт өвчнүүд:

4.2.2а Монгол Улсад тэмдэглэгдсэн байгалийн голомтот халдварт өвчнүүд:


- ✓ Тарваган тахал
- ✓ Хулгана тахал
- ✓ Хүний боомын өвчлөл
- ✓ Шувууны томуу

4.2.2б Зөөвөрлөгдөн орж ирэх зоонозын халдварт өвчнүүд:

- ✓ Эболын халдварт
- ✓ Марбургийн халдварт
- ✓ Хумхаа
- ✓ Шар чичрэг
- ✓ Ласса чичрэг
- ✓ Денгийн халууралт
- ✓ Баруун нилийн халдварт

4.3 Хордлогын гаралтай өвчнүүд (ижил төрлийн шинж тэмдэг бүхий 3 болон түүнээс дээш тохиолдол бүртгэгдсэн үед)

- ✓ Зүрх судасны тогтолцоонд анхдах нөлөөт эмийн хордлого
- ✓ Хаа ч ангилаагүй ерөнхий ба цусанд анхдах нөлөөт бодист хордлого
- ✓ Амьсгалын тогтолцоонд, гилгэр ба араг ясны булчинд анхлан нөлөөлөх эмийн хордлого
 - ✓ Архины хордуулах нөлөө
 - ✓ Органик уусгуурын хордуулах нөлөө
 - ✓ Унгадлын хийн (карбонмоноксидын) хордуулах нөлөө
 - ✓ Тодорхойгүй бусад бодисын хорт нөлөө
 - ✓ Шавьж, мэрэгч устгуурын хордуулах нөлөө.


 Эрүүл мэндийн сайдын
 2018 оны 12 сарын 11.. өдрийн 9:57
 дугаар тушаалтын хоёрдугаар хавсралт

**Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлэх мэдээ,
мэдээллийн төрөл, давтамж, мэдээлэх хугацаа**

№	Мэдээллийн төрөл	Мэдээллийг бэлтгэж ирүүлэх байгууллага	Мэдээллийг бэлтгэн ирүүлэх хугацаа	Зөвлөлд хүргүүлэх газар, хэлтэс	Мэдээллийг зөвлөлд хүргэх хугацаа
1. Шуурхай мэдээ					
1.1	Хүн амын өвчлөл, эндэгдлийн мэдээ	Эрүүл мэндийн хөгжлийн төв	Тухай бүр	Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар	Тухай бүр
1.2	Шинэ болон сэргэн тархаж буй халдвартын болзошгүй аюулаас сэргийлэх бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ, халдвэр, хордлогын өвчлөл, эрсдэлийн тухай	Халдварт өвчин судлалын үндэсний төв Зоонозын өвчин судлалын үндэсний төв	Тухай бүр	Нийгмийн эрүүл мэндийн газар, Олон нийттэй харилцах, тандалт, шуурхай удирдлагын хэлтэс	Тухай бүр
1.3	Товлолын болон тархвар зүйн вакцин, биобэлдмэлийн нөөцийн хүрэлцээ, хангамж, устгалын тухай	Халдварт өвчин судлалын үндэсний төв Зоонозын өвчин судлалын үндэсний төв	Тухай бүр	Нийгмийн эрүүл мэндийн газар, Олон нийттэй харилцах, тандалт, шуурхай удирдлагын хэлтэс	Тухай бүр
2. Танилцуулах мэдээ					
2.1	Хүн амын өвчлөл, эндэгдлийн мэдээ	Эрүүл мэндийн хөгжлийн төв	VI сарын гуравдугаар 7 хоног, XII сарын 10	Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар	VI сарын сүүлийн 7 хоног, XII сарын 15
2.2	Төрөл ойртолт, түүний хүн амд эзлэх зохицтой харьцааны алдагдал, архи, мансууруулах болон сэтгэцэд хүчтэй нөлөөлөх бодис	Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	XII сарын 10	Эмнэлгийн тусlamжийн газар, Нийгмийн эрүүл мэндийн газар	XII сарын 15

	хэрэглэх, донтох эмгэг, сэтгэцийн эмгэг зан үйл, оюуны хомсдолтой хүмүүсийн мэдээ, судалгаа				
2.3	Шинэ болон сэргэн тархаж буй халдвартын болзошгүй аюулаас сэргийлэх бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ, халдвар, хордлогын өвчлөл, эрсдэлийн тухай	Халдварт өвчин судлалын үндэсний төв Зоонозын өвчин судлалын үндэсний төв	XII сарын 10	Нийгмийн эрүүл мэндийн газар, Олон нийттэй харилцах, тандалт, шуурхай удирдлагын хэлтэс	XII сарын 15
2.4	Товлолын болон тархвар зүйн вакцин, биобэлдмэлийн нөөцийн хүрэлцээ, хангамж, устгалын тухай	Халдварт өвчин судлалын үндэсний төв Зоонозын өвчин судлалын үндэсний төв	XII сарын 10	Нийгмийн эрүүл мэндийн газар, Олон нийттэй харилцах, тандалт, шуурхай удирдлагын хэлтэс	XII сарын 15
2.5	Эм, биобэлдмэлийн чанар, аюулгүй байдлын үйл ажиллагааны тухай мэдээ	Эрүүл мэндийн байгууллагууд	XII сарын 10	Эм, үйлдвэрлэл, технологийн газар, Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн хэлтэс	XII сарын 15
2.6	Эмнэлзүйн лабораторийн гадаад дотоод чанарын хяналтын тухай	Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	XII сарын 10	Эм, үйлдвэрлэл, технологийн газар	XII сарын 15
2.7	Эрүүл мэндийн салбарт шинээр болон шинэчилсэн стандартуудын тухай		VI сарын гуравдугаар 7 хоног, XII сарын 10	Эм, үйлдвэрлэл, технологийн газар	VI сарын сүүлийн 7 хоног, XII сарын 15
2.8	Зүрх, мэдрэлийн төвийн үйл ажиллагаа, эрсдэлийн мэдээ	Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	VI сарын гуравдугаар 7 хоног, XII сарын 10	Эмнэлгийн тусlamжийн газар	VI сарын сүүлийн 7 хоног, XII сарын 15
2.9	Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт, явцын тухай мэдээ, тайлан	Эрүүл мэндийн байгууллагууд	VI сарын гуравдугаар 7 хоног, XII сарын 10	Нийгмийн эрүүл мэндийн газар, Эмнэлгийн тусlamжийн газар	VI сарын сүүлийн 7 хоног, XII сарын 15

3. Танилцуулах тойм мэдээ					
3.1	Халдварт бус өвчний эрт илрүүлгийн хамрагдалт, хянах, эмчлэх үйл ажиллагаа, үзүүлэлтийн тухай мэдээ, тайлан	Эрүүл мэндийн байгууллагууд	VI сарын гуравдугаар 7 хоног, XII сарын 10	Эмнэлгийн тусlamжийн газар Нийгмийн эрүүл мэндийн газар	VI сарын сүүлийн 7 хоног, XII сарын 15
3.2	ХДХВ/ДОХ-ын халдварын тохиолдол, эрсдэлт байдлын тухай	Халдварт өвчин судлалын үндэсний төв	Улирал бүрийн гуравдугаар 7 хоног	Нийгмийн эрүүл мэндийн газар	Улирал бүрийн сүүлийн 7 хоног
3.3	Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн үйл ажиллагаа, эрсдэлийн мэдээ	Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	VI сарын гуравдугаар 7 хоног, XII сарын 10	Эмнэлгийн тусlamжийн газар	VI сарын сүүлийн 7 хоног, XII сарын 15
3.4	Цэргийн насны иргэдийн эрүүл мэндийн байдлын тухай мэдээ		XII сарын 10	Эмнэлгийн тусlamжийн газар	XII сарын 15